


НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН САРЫН МЭДЭЭНИЙ ТОЙМ

2012 оны
05-р сар

Нийгмийн даатгалын санд 2012 оны 5-р сарын 31-ний байдлаар өссөн дүнгээр 276.6 тэрбум төгрөгийн шимтгэлийн орлого төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 122.0 хувиар биелүүлсэн байна. Даатгалын сангуудаас давхардсан тоогоор 1524.6 мянган иргэний тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зардалд нийт 305.0 тэрбум төгрөг зарцуулжээ. Улсын төсвөөс 1995 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон иргэдийн болон цэргийн тэтгэвэрт 123.8 тэрбум төгрөгийг тэтгэврийн даатгалын санд шилжүүлжээ.

Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага /Тэрбум төгрөгөөр/



Нийгмийн даатгалын хамралт, шимтгэлийн орлого

2012 оны 5-р сарын мэдээгээр нийгмийн даатгалд 26.4 мянган аж ахуйн нэгж байгууллага, 555.0 мянган заавал даатгуулагч, 65.7 мянган сайн дурын даатгуулагч, эрүүл мэндийн даатгалд 1501.7 мянган даатгуулагч хамрагдсан байна.


Нийгмийн даатгалын таван төрлийн санд энэ оны 5-р сард 66.5 тэрбум төгрөгийн шимтгэлийн орлого төвлөрүүлсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 22.1 тэрбум төгрөгөөр өсчээ.

Нийгмийн даатгалын сангуудаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, тусламж, үйлчилгээний зардалд энэ сард 71.6 тэрбум төгрөг зарцуулжээ.


Тэтгэврийн даатгалын сан

Тухайн сард тэтгэврийн даатгалын санд 42.3 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлж, сангаас өндөр насны, тахир дутуугийн, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч 296.5 мянган иргэдийн тэтгэвэрт 49.0 тэрбум төгрөг зарцуулжээ. Нийт зардлын 72.3 хувь буюу 35.4 тэрбум төгрөгийг өндөр насны тэтгэвэр авагч 207.0 мянган иргэнд зарцуулсан байна.

Тэтгэврийн даатгалын сангийн орлого, зарлага /Тэрбум төгрөгөөр/



Тэтгэмжийн даатгалын сангийн орлого, зарлага /Тэрбум төгрөгөөр/



Тэтгэмжийн даатгалын сан

Тэтгэмжийн даатгалын сангаас хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны, оршуулгын тэтгэмж авсан 14.0 мянган иргэнд 3.8 тэрбум төгрөг зарцуулсан байна. Нийт 70.3 хувь буюу 2.7 тэрбум төгрөгийг жирэмсний болон амаржсаны тэтгэмжид зарцуулжээ. Тэтгэмжийн даатгалын сангийн орлогыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 853.5 сая төгрөгөөр, зарлага 1130.2 сая төгрөгөөр өссөн байна.

Сарын статистик мэдээ

<u>ҮОМШӨ-ний даатгалын сан</u>				<u>ҮОМШӨ-ний даатгалын сангийн зарлага /Сая төгрөгөөр/</u>							
<p>Энэ сард тахир дутуугийн болон тэжээгчээ алдсаны 6.8 мянган тэтгэвэр авагчдад 1.7 тэрбум төгрөг, 107 хүнд хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, төлбөр, сувиллын зардал, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд нийт 163.9 сая төгрөгийг зарцуулав. Сангийн зардал өмнөх оны мөн үеэс 311.8 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.</p>				2011_5 сар	2012_5 сар	Зөрүү					
				Тахир дутуугийн	1 324.4	1 549.8	225.5				
				Тэжээгчээ алдсаны	137.8	145.1	7.3				
				Тэтгэмж, төлбөрийн	34.9	29.9	5.0				
				Сувиллын	49.9	134.0	84.1				
Нийт дүн		1 547.0	1 858.8	311.8							
<u>Ажилгүйдлийн даатгалын сангийн зарлага /Сая төгрөгөөр/</u>				<u>Ажилгүйдлийн даатгалын сан</u>							
		2011_5 сар	2012_5 сар	<p>Ажилгүйдлийн даатгалын сангаас 2012 оны 5-р сард 803 хүнд 465.6 сая төгрөгийг ажилгүйдлийн даатгалын тэтгэмж, сургалтын зардалд зарцуулсан. Сангийн зардал 2011 оны мөн үетэй харьцуулахад 58.5 сая төгрөгөөр буурсан байна.</p>							
Ажилгүйдлийн тэтгэмж	522.8	465.1	57.7								
Сургалтын зардал	1.3	0.5	0.8								
Нийт дүн	524.1	465.6	58.5								
<u>Эрүүл мэндийн даатгалын сан</u>				<u>Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага /Сая төгрөгөөр/</u>							
<p>2012 оны 5-р сард эрүүл мэндийн даатгалын сангаас эмнэлгийн тусламж, үйлчилгээ авсан, рашаан, сувилалын зардал, эмийн үнийн хөнгөлөлт эдэлсэн 245.9 мянган хүний зардалд 16.5 тэрбум төгрөг зарцуулсан байна. Нийт зардлын 96.0 хувийг эмнэлгийн тусламж үйлчилгээний зардалд, 1.3 хувийг рашаан сувилалд, 2.7 хувийг эмийн үнийн хөнгөлөлтөд тус тус зарцуулав. Сангийн орлого 2011 оны мөн үетэй харьцуулахад 4.1 тэрбум төгрөгөөр, зардал 7.7 тэрбум төгрөгөөр өссөн.</p>				2011_5 сар	2012_5 сар	Зөрүү					
				Эмнэлгийн эмчилгээний зардал	8 325.7	15 855.6	7 529.8				
				Рашаан сувиллын зардал	226.3	212.8	13.4				
				Эмийн үнийн хөнгөлөлт	204.9	438.0	233.1				
				Нийт дүн	8 756.9	16 506.4	7 749.5				
<u>Нийгмийн даатгалын шимтгэлийн 5-р сарын авлага /сая төгрөгөөр/</u>				<u>Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага</u>							
 <p style="text-align: center;">0-30 хоног 31-60 хоног 61-90 хоног 91-120 хоног дээш хоногтой</p>				<p>Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага 19.7 тэрбум төгрөг байна. Нийт шимтгэлийн авлагын 89.3 хувь буюу 17.6 тэрбум төгрөгийг аж ахуйн нэгж байгууллагуудын авлага эзэлж байна. Мөн авлагын 38.9 хувийг буюу 7.7 тэрбум төгрөгийг 121 ба түүнээс дээш хоногтой хуримтлагдсан авлагын дүн эзэлж байна.</p>							
<u>Үйл ажиллагааны зардал /сая төгрөгөөр/</u>				<u>Үйл ажиллагааны зардал</u>							
		2011_5 сар	2012_5 сар	Өөрчлөлт							
				Тоогоор	Хувиар						
Цалингийн сан, нийгмийн даатгалын шимтгэл	3382.6	4209.1	826.5	124.4%		<p>Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны зардалд нийт 8953.2 сая төгрөг төлөвлөснөөс 5568.0 сая төгрөг зарцуулж, 3385.2 сая төгрөг хэмнэгдсэн байна. Уг зардал нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 124.0% буюу 1078.4 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.</p>					
Бараа үйлчилгээний бусад зардал	1107.0	1358.9	251.9	122.8%							
Дүн	4489.6	5568.0	1078.4	124.0%							